



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 10

Номгон

**Албан тушаалын сул орон тоонд  
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4, 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Энэ оны 4 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан Төрийн захиргааны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул ажлын байрыг нөхөх тусгай шалгалтын тайланг хянан үзээд сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан Г.Жавзмааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Жендерийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр, Т.Мөнхзулыг Орон нутгийн өмчийн газрын өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтнээр, Д.Төмөрбаатарыг Дотоод хяналт шалгалтын мэргэжилтнээр, Б.Ууганбаярыг Худалдан авах ажиллагааны газрын дотоод хяналт, шалгалтын мэргэжилтнээр, Ш.Даваацэрэнг Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтнээр, Ц.Цэрэнбатыг Мал эмнэлгийн газрын Шинэжинст сум дахь Мал эмнэлгийн Тархвар зүйчээр, О.Дашдавааг Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын Эрүүл мэнд биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтнээр, Ж.Баасансүрэнг Баянхонгор сумын 2 дугаар багийн зохион байгуулагчаар, О.Амарсайханыг Баянхонгор сумын 10 дугаар багийн зохион байгуулагчаар, Г.Гүндалайг Баянхонгор сумын 4 дүгээр багийн зохион байгуулагчаар тус тус томилуулахаар нэрийг дэвшүүлсүгэй.

2. Төрийн албаны тусгай шалгалтад хамгийн өндөр оноо авч сул ажлын байранд нэр дэвшигдсэн иргэдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 22.1.3, 22.1.5-д тавигдсан шаардлагыг хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаас авч хянахыг холбогдох байгууллагын дарга нарт сануулсугай.

642213139

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомжийг чанд сахиж, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллахыг тухайн албан тушаалд нэр дэвшигчдэд зөвлөсүгэй.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ